


# ЭКСПОРТЫН ТӨРӨЛЖИЛТ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

## 2018 ОНЫ 03 ДУГААР САР

**Экспортын төрөлжилт**

**Боловсронгуй байдлын индекс**

**Бүтээгдэхүү-ний орон зай**

Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч Б.Хүслэн

Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн захирал Л.Даваажаргал

*Энд дурьдагдах аливаа дүгнэлт, санал нь зөвхөн хувь судлаачийн үзэл бодол, байр суурийг илэрхийлэх болно.*

# АГУУЛГА


**01 Судлагдсан байдлын тойм**

C. Hidalgo ба R. Hausmann, “The Building Blocks of Economic Complexity,”

**02 Экспортын дэд бүтэц (суурь орчин)**

Газарзүйн байршил, бодлого, институцийн хөгжил, санхүүжилтийн орчин.

**03 Экспортын орлогын бүтэц**

Түүхэн экспортын орлого, экспортлож буй бүтээгдэхүүн.

**04 Уул уурхайн бус экспортын тэргүүлэх салбар**

Эдийн засгийн цогц байдлын индекс, бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ.


**ЭКСПОРТЫН ТӨРӨЛЖИЛТ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ**

Эдийн засгийн өсөлт

Ажил эрхлэлт

Төлбөр-ийн тэнцэл

**Экспортын орлого**

Шууд хамааралтай

Экспортын орлого (2010-2014)

Уул уурхайн салбар 89.4 %

Бусад салбар 10.6 %

**Түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ**

1. Экспортын дэд бүтэц, суурь орчны асуудлыг тодорхойлох
2. Экспортын орлогын бүтээгдэхүүний бүтцийг шинжлэх
3. Экспортыг төрөлжүүлэхэд тэргүүлэх салбарыг тодорхойлох

**Олон улсад судлагдсан байдал**

Дотоодод судлагдсан байдал

01 C. Hidalgo, R. Hausmann (2007) нь экспортолж буй бүтээгдэхүүний төрлийг сайжруулах нь эдийн засгийн өсөлтийг бий болгодог гэж үзсэн. Энэхүү судалгаанд бүтээгдэхүүний хоорондын харилцаа холбоог шинжилж, бүтээгдэхүүний орон зай **(Product space)** гэсэн ойлголтыг бий болгожээ.

02 C. Hidalgo, R. Hausmann (2009) нь эдийн засгийн цогц байдалд тулгуурласан эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулсан. Судалгааны ажлаар олон улсын худалдааны тоон мэдээллийг ашиглан эдийн засгийн цогц байдлын индекс (**economic complexity index – ECI**) тооцох аргыг танилцуулсан.

03 R. Hausmann, B. Cunningham (2014) нь Уганда улсын экспортын хөгжлийн стратеги боловсруулжээ. Уганда нь байгалийн баялаг ихтэй улс орон бөгөөд баялгийн хараалд өртөж, газрын тосноос хэт хамааралтай экспорттой болсон. Энэхүү судалгаанд бусад тэргүүлэх салбар, бүтээгдэхүүнийг эдийн засгийн цогц байдлын индекс (ECI), бүтээгдэхүүний орон зайг ашиглан тодорхойлсон байна.

Олон улсад судлагдсан байдал

**Дотоодод судлагдсан байдал**

**01** C. Hidalgo, R. Hausmann (2007) нь экспортолж буй бүтээгдэхүүний төрлийг сайжруулах нь эдийн засгийн өсөлтийг бий болгодог гэж үзсэн. Энэхүү судалгаанд бүтээгдэхүүний хоорондын харилцаа холбоог шинжилж, бүтээгдэхүүний орон зай **(Product space)** гэсэн ойлголтыг бий болгожээ.

**02** C. Hidalgo, R. Hausmann (2009) нь эдийн засгийн цогц байдалд тулгуурласан эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулсан. Судалгааны ажлаар олон улсын худалдааны тоон мэдээллийг ашиглан эдийн засгийн цогц байдлын индекс (**economic complexity index – ECI**) тооцох аргыг танилцуулсан.

**03** R. Hausmann, B. Cunningham (2014) нь Уганда улсын экспортын хөгжлийн стратеги боловсруулжээ. Уганда нь байгалийн баялаг ихтэй улс орон бөгөөд баялгийн хараалд өртөж, газрын тосноос хэт хамааралтай экспорттой болсон. Энэхүү судалгаанд бусад тэргүүлэх салбар, бүтээгдэхүүнийг эдийн засгийн цогц байдлын индекс (ECI), бүтээгдэхүүний орон зайг ашиглан тодорхойлсон байна.

**04** Ган-Очир (2017) нь түүхий эдийн үнийн уналт нь макро эдийн засгийн түвшинд, төсвийн бүрдэлт, мөнгөний болон ханшийн бодлогоор гэсэн гурван сувгаар эдийн засагт нөлөө үзүүлдэг болохыг онцолжээ. Тогтвортой, өндөр өсөлтийг дунд болон урт хугацаанд хангахын тулд уламжлалт түүхий эдийн экспортоос салж, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна гэж үзсэн байна.

**05** Ган-Очир (2017) нь нь эдийн засгийг төрөлжүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх нь туйлын чухал ач холбогдолтой гэж үзсэн. Үүний тулд нөөцийн орлогыг нийгмийн хувьд үр ашиг өндөртэй байх дэд бүтцийн төслүүд, хүмүүн капиталд хөрөнгө оруулахаас гадна өөрийн орны онцлогт тохирсон, олон улсад өрсөлдөх чадвартай салбарыг дэмжихэд зарцуулах шаардлагатайг онцолсон.

Газарзүйн байршил

Экспортыг нэмэгдүүлэх бодлого

Институцийн хөгжил

Санхүүжилтийн орчин

## Зураг 1. Монгол улсын экспорт, газар зүйн байршлаар (2015)




*Эх сурвалж: Atlas of economic complexity*

## Зураг 2. Экспортын орлогын өөрчлөлт, улсаар




## Зураг 3. Экспортын орлогод эзлэх хувь, улсаар (2015)



- Экспортыг төрөлжүүлж, орлогоо нэмэгдүүлж чадсан орнуудын туршлагаас үзэхэд, экспортын бодлого нь тогтвортой, хэрэгжүүлэх механизм нь тодорхой байсан учраас амжилттай хэрэгжиж байжээ. Жишээлбэл: БНСУ, Сингапур, Тайланд гэх мэт.

- Тухайлбал, БНСУ нь экспортын бодлогыг үе шаттайгаар шинэчлэн боловсруулж, шаардлагатай суурь орчин, дэд бүтцийг тухай бүр нь бүрдүүлж, хэрэгжүүлэх механизмыг тодорхой зааж өгч байсны үр дүнд экспортын тогтвортой бодлого амжилттай түвшинд хэрэгжсэн байна. (B. Song, 1990)

- Монгол улсад экспортыг дэмжих бодлого байгаа ч хэрэгжүүлэх стратеги, арга хэрэгсэл нь тодорхойгүй хэвээр байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар 1998 оны 158 дугаар тогтоолоор “Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг 1998-2010 онд хэрэгжүүлэхээр баталсан. Гэсэн хэдий ч хэрэгжүүлэх механизм, санхүүгийн эх үүсвэрийг нь тодорхой заагаагүйгээс энэхүү хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй. Монгол Улсын Засгийн газраас 2013 онд баталсан “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт 18 хувь байсан.

- “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2016 оны 4 сард дахин баталсан. Цаашид хэрэгжүүлэх зорилт нь арга хэмжээний механизм, санхүүгийн эх үүсвэр нь тодорхойгүй нөхцөлд мөн л хэрэгжихгүй байх эрсдэлтэй. (Бямбацогт, 2012 )

**Хүснэгт 1. Улс орнуудын экспортыг дэмжих байгууллагууд**

| № | Улс орны нэр | Экспортыг дэмжих байгууллага | Төсөв (сая ам.доллар) | Ажилтнуу-дын тоо | Санхүүжилт | Үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Чили | Prochile | 33 | 384 | Улсын төсөв | Байнгын |
| 2. | Бразил | Apex | 120 | 214 | Улсын төсөв | Байнгын |
| 3. | Монгол | Экспортыг дэмжих төсөл | 20 | 12 | Дэлхийн банк | 4.5 жил |
| 4. | Монгол | ТРАМ | – | – | Европын холбоо | эхлээгүй |

*Эх сурвалж: Volpe Martincus (2010), Экспортыг дэмжих төсөл*

- Сүүлийн хорин жилд дэлхий дахинд худалдааг дэмжих байгууллага (Trade promotion organization)-ын тоо 3 дахин өсчээ. (D. Lederman, 2008)
- Чили, Бразил зэрэг орнуудад экспортыг дэмжих байгууллага нь улсын төсвөөс бүрэн санхүүждэг буюу санхүүгийн чадавх өндөртэй байдаг.
- Мөн тухайн байгууллагууд нь цөөнгүй тооны ажилтантай бөгөөд байнгын үйл ажиллагаа явуулдаг, тэдгээрийн гол онцлог нь бусад улс оронд дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчилж таниулах нэгж ажиллуулдаг ажээ.

- Монгол Улсын Засгийн газраас гадаад худалдааны чиглэлээр институцийн чадавхыг сайжруулах чиглэлээр дорвитой арга хэмжээ авч байгаагүй ажээ (Бямбацогт, 2012).
- Жижиг дунд үйлдвэрлэлийн гадаад худалдааг дэмжих чиглэлээр Экспортыг дэмжих төсөл, Трам төслүүд байна.
- Улсын төсвөөс санхүүждэг, байнгын үйл ажиллагаатай, санхүүгийн чадавх болон ажилтнуудын тоо хүрэлцээтэй экспортыг дэмжих байгууллага Монгол улсад байхгүй байна.

Газарзүйн байршил

Экспортыг нэмэгдүүлэх бодлого

Институцийн хөгжил

Санхүүжил-тийн орчин

## Зураг 4. Улс орнуудын нэрлэсэн зээлийн хүү, %




- Монгол улсын нэрлэсэн зээлийн хүүг гадаад худалдаа эрчимтэй хөгжсөн орнуудын хүүтэй харьцуулахад өндөр байна.
- ЖДҮ-ийн судалгаагаар зээлийн хүү хамгийн их хүндрэл учруулж буйг харуулжээ. (Монголбанк, 2017)
- Манай оронд гадаад худалдааны санхүүжилтийн төрөлжсөн санхүүгийн байгууллага байхгүй байна.

- Олон улсад засгийн газар экспортлогч байгууллагуудын зээлийн хүртээмжийг сайжруулахын тулд хэд хэдэн аргаар хөндлөнгөөс санхүүгийн зах зээлд оролцдог байна.
- Ихэвчлэн жижиг компаниудад олгож буй голлох үйлчилгээ нь худалдааны санхүүжилт буюу зээлийн татаас олгох, зээлийн зах зээлийн өрсөлдөөнийг урамшуулах, экспортын хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн баталгаа олгох зэрэг юм.

**Түүхэн экспортын орлого**

**Экспортлож буй бүтээгдэхүүн**

## Зураг 5. Экспортын орлого




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Тухайлбал, экспортын орлого 2009 онд 1.9 тэрбум ам.доллар буюу хамгийн бага байсан бол 2014 онд 5.8 тэрбум ам.доллар буюу хамгийн их байжээ.
- Харин өсөлтийн хувь 2009 онд хамгийн бага буюу –24 хувь, 2011 онд хамгийн их буюу 64 хувьд хүрч байжээ

## Зураг 6. Экспортын бүтээгдэхүүний ангилал, төрлөөр




*Эх сурвалж: Монголбанк*

**Зураг 7. Уул уурхайн салбарын экспортын орлогод эзлэх хувь**




*Эх сурвалж: Монголбанк*

- Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогын хэт өндөр хэмжээ нь гадаад валютын дотогшлох урсгалыг ихээр нэмэгдүүлж, дотоодын валютын ханшийг чангаруулдаг.
- Баялаг ихтэй байх нь улс орны бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлж, улс төрийн орчинд авлига, хээл хахууль зэрэг цэцэглэх хүчин зүйл болдог.
- Уул уурхайн салбар хэт хөгжсөнөөр ихэнх боловсон хүчин уул уурхайн салбарын мэргэжилтэй болж, бусад салбарт боловсон хүчин хангалтгүй болох нөхцөлийг бүрдүүлдэг.

**Зураг 8. Экспортын орлогын ангилал, төрлөөр (2016)**




*Эх сурвалж: Монголбанк*

- Харин 2016 оны экспортын орлогын бүтцийг үзэхэд, үлдсэн 13 хувийн хамгийн их хувийг мал аж ахуй, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн эзэлж байна

**Эдийн засгийн цогц байдлын индекс**

Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ

Цаашид төвлөрөх салбар

Тухайн улсын нөөц, бүтээгдэхүүний мэдлэг *(Know How)* = ҮСЭГ — А, Б, В гэх мэт

Тухайн улсын экспортлож буй бүтээгдэхүүн = ҮГ — ААВ, ВААР гэх мэт

| | |
|---|---|
| **Нийт бүтээсэн үгийн тоо** | *Экспортын бүтээгдэхүүний төрөлжилт* |
| + | |
| **Тухайн үгийг бүтээж чадах бусад тоглогчид** | *Экспортын бүтээгдэхүүний боловсруулсан байдал* |
| = | |
| **Economic Complexity Index (ECI)** | *Эдийн засгийн цогц байдлын индекс (Eigen vector, eigen value )* |

**Хүснэгт 2. Улс орнуудын эдийн засгийн цогц байдлын индекс (ECI)**

| Эрэмбэ | Товчлол | Улс | ECI утга | | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | JPN | Япон | 2.26 | – | 0 |
| 2 | CHE | Швейцар | 2.18 | – | 0 |
| 3 | DEU | Герман | 1.99 | – | 0 |
| 4 | KOR | Өмнөд Солонгос | 1.79 | – | 0 |
| 5 | CZE | Чех | 1.69 | ▲ | 3 |
| 6 | SWE | Швед | 1.69 | ▼ | 1 |
| 7 | AUT | Австри | 1.67 | ▼ | 1 |
| 8 | USA | АНУ | 1.62 | ▲ | 1 |
| 9 | GBR | Нэгдсэн вант улс | 1.62 | ▼ | 2 |
| 10 | FIN | Финланд | 1.55 | – | 0 |
| **99** | **MNG** | **Монгол** | **–1.11** | ▲ | **2** |

Atlas of Economic Complexity нь улс орон бүрийн хувьд ECI-ийг тооцож тэдгээрийг эрэмбэлдэг. 2016 оны байдлаар манай орны **ECI нь –1.11** буюу нийт **122 орноос 99-д** эрэмбэлэгдэж байна

**Зураг 9. Эдийн засгийн цогц байдлын индекс, орлогын хамаарал**




**Зураг 10. Эдийн засгийн цогц байдлын индекс, ДНБ-ий өсөлтийн хамаарал**




*Эх сурвалж: Atlas of economic complexity (Hausmann ба бусад, 2011)*

- Энэхүү индекс нь орлого, үнэ, бусад баялагтай холбоотой хэмжигдэхүүний тоон мэдээллийг огт ашиглаагүй, зөвхөн тухайн улс хэдэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, тухайн бүтээгдэхүүнийг өөр хэдэн улс үйлдвэрлэдгийг хэмждэг байна.
- Улс орнуудаар нэг хүнд ногдох орлого, эдийн засгийн цогц байдлын индексийг харьцуулж үзэхэд, ECI нь тус үзүүлэлтийн вариацийн **75 хувийг** тайлбарладаг байна. (R. Hausmann, 2011)

Эдийн засгийн цогц байдлын индекс

**Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ**

Цаашид төвлөрөх салбар

## Зураг 11. Бүтээгдэхүүний орон зай




*Эх сурвалж: Atlas of economic complexity*

- Улс орны орлогод тухайн улсын бүтээгдэхүүний мэдлэг шууд нөлөө үзүүлж байдаг. Жишээ нь Уганда улс цамц үйлдвэрлэдэг бөгөөд шинээр хүрэм юмуу мотор хоёрын аль нэгийг үйлдвэрлэхээр болсон тохиолдолд, хүрэмийг үйлдвэрлэх болно.
- Hausmann and Klinger (2007) нь анх энэхүү таамаглалыг дэвшүүлсэн бөгөөд хоёр бүтээгдэхүүний мэдлэгийн ялгаатай байдлыг олон улсын худалдааны 2006-2008 оны тоон мэдээллийг ашиглан хэмжиж, орон зайд тэр хэмжээгээр нь зайтай байршуулан **бүтээгдэхүүний орон зай (Product space)** хэмээх ойлголтыг бий болгосон.
- Бүтээгдэхүүний орон зайн дүрслэлд харуулж буй зангилаа цэгүүд нь бүтээгдэхүүнийг, цэгийн хэмжээ нь дэлхийн худалдаанд эзлэх хувийг илтгэнэ. Байршиж буй бүтээгдэхүүнүүдийн зай ойр байх тусам тухайн бүтээгдэхүүнүүдийг нэг улс үйлдвэрлэдэг байх магадлал өндөртэй гэсэн үг юм

Эдийн засгийн цогц байдлын индекс

**Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ**

Цаашид төвлөрөх салбар

**Зураг 12. Бүтээгдэхүүний шинж чанар**




*Эх сурвалж: Atlas of economic complexity (Hausmann et al., 2011)*

- Одоогийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний мэдлэг нь ирээдүйд хөгжүүлж болох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тодорхойлдог. **(Distance)**
- Мөн цогц байдлын индексийг бүтээгдэхүүн тус бүрээр тооцож болдог бөгөөд **PCI (product complexity index)** гэж нэрлэдэг. Харин нэг бүтээгдэхүүний бусад бүтээгдэхүүнд шилжих боломжийг **хүрэх боломж (opportunity gain)** эсвэл **дундаж холбоос (average connectedness)** гэж нэрлэдэг.
- Бүтээгдэхүүн тус бүрийн PCI болон дундаж холбоос нь **шугаман хамааралтай** байна. Энэ нь аливаа бүтээгдэхүүнийг илүү боловсруулах тусам бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлдэг гэсэн үг юм.

Эдийн засгийн цогц байдлын индекс

**Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ**

Цаашид төвлөрөх салбар

**Зураг 13. Япон улсын бүтээгдэхүүний орон зай (2016)**




*Эх сурвалж: Atlas of economic complexity*

- Япон улс нь экспортын орлогоороо дэлхийн тэргүүлэх улсын нэг бөгөөд бүтээгдэхүүний орон зайн шинжилгээнээс үзэхэд, бүхий л төрлийн өнгийн цэг (бүтээгдэхүүн)-тэй буюу **төрөлжилтийн түвшин өндөртэй**, цэгүүд нь ихэвчлэн голлох хэсэг рүү байрласан **(боловсруулсан)** байна.
- Япон улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүд нь **машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл** болон **химийн үйлдвэрлэл** юм

Эдийн засгийн цогц байдлын индекс
Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ
Цаашид төвлөрөх салбар

**Зураг 14. Солонгос улсын бүтээгдэхүүний орон зай (2016)**




*Эх сурвалж: Atlas of economic complexity*

- БНСУ-ын хувьд бүтээгдэхүүний **төрөлжилт өндөр** байгаа бөгөөд, зангилааны цэгүүд нь төв хэсэг рүү төвлөрсөн буюу **боловсруулсан бүтээгдэхүүн** их хэмжээгээр экспортолдог байна.
- БНСУ-ын экспортын голлох бүтээгдэхүүнүүд нь **машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл** болон **химийн үйлдвэрлэл** зэрэг болно.

Эдийн засгийн цогц байдлын индекс

**Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ**

Цаашид төвлөрөх салбар

**Зураг 15. Монгол улсын бүтээгдэхүүний орон зай (2016)**




*Эх сурвалж: Atlas of economic complexity*

- Монгол улсын экспортын бүтээгдэхүүний төрөлжилтийг хөгжингүй орнуудтай харьцуулахад их хэмжээгээр дутмаг байна.
- Нөгөө талаас, уул уурхай болон бусад төрлийн бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг түүхий (огт боловсруулаагүй) байдлаар экспортолдог тул, зангилааны цэгүүд нь **зах хэсгээрээ төвлөрсөн**, төв хэсгийн зангилааны цэг буюу боловсруулан экспортолдог бүтээгдэхүүн ховор байна.
- Иймд уул уурхайн бус тэргүүлэх **салбар (бүтээгдэхүүн)-ийг тодорхойлох**, уул уурхайн салбарын түүхий эдийг **боловсруулан экспортлох** боломжийг эрэл хийх нь чухал асуудал болоод байна.

**Зураг 16. Үр ашигт хязгаар:** *А, Б, В, Г нь бүтээгдэхүүн: Зай (А)=Зай (Б), ECI (А)>ECI (Б); ECI (А)=Зай (Б), ECI (А)>ECI (Б)*




**Зураг 17. Үр ашигт хязгаар (ECI, зай)**




**Зураг 18. Үр ашигт хязгаар (OG, зай)**




Эдийн засгийн цогц байдлын индекс
Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ
Цаашид төвлөрөх салбар

Эдийн засгийн цогц байдлын индекс
Бүтээгдэхүүний орон зайн шинжилгээ
Цаашид төвлөрөх салбар

**Хүснэгт 3. Экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах бүтээгдэхүүний жагсаалт:**

| Д/д | Бүтээгдэхүүн | PCI | Opportunity gain | Distance |
|---|---|---|---|---|
| 1 | Газрын тосны үр, тослог жимс, эмчилгээний ургамал | –0.905 | 0.0211 | 0.942 |
| 2 | Түлш, газрын тос | –0.181 | 0.244 | 0.945 |
| 3 | Хүдэр, шаар, үнс хөө | –1.65 | –0.00681 | 0.929 |
| 4 | Савхи, арьсан бүтээгдэхүүн | –1.37 | 0.0524 | 0.937 |
| 5 | Элсэн чихэр, чихэр | –0.713 | –0.103 | 0.943 |
| 6 | Ноос, амьтны үс | 0.236 | 0.277 | 0.945 |
| 7 | Амьд амьтан | 0.125 | 0.163 | 0.946 |
| 8 | Мах | 0.663 | 0.381 | 0.949 |
| 9 | Үр тариа | 0.310 | 0.279 | 0.950 |
| 10 | Сүүн бүтээгдэхүүн, өндөг, зөгийн бал | 0.522 | 0.282 | 0.951 |
| 11 | Хивс, бусад шалны нэхмэл дэвсгэр | 0.381 | 0.375 | 0.952 |
| 12 | Согтууруулах төрлийн ундаа | 0.231 | 0.240 | 0.954 |
| 13 | Эфирийн тос, үнэртэн, гоо сайхны бэлдмэл | 0.944 | 0.440 | 0.956 |
| 14 | Модны целлюлоз, цаас, цаасан карт | 1.610 | 0.541 | 0.959 |
| 15 | Альбуминойдын бодис, цавуу, энзим | 1.890 | 0.727 | 0.961 |
| 16 | Эмийн бүтээгдэхүүн | 2.340 | 0.916 | 0.965 |
| 17 | Үйлдвэрийн машин, эд ангиуд | 2.680 | 0.987 | 0.970 |

*Эх сурвалж: Atlas of economic complexity*

## Дунд болон урт хугацаа

| | Жин | Зай | Complexity | Opp.gain |
|---|---|---|---|---|
| SBI | | 0.2 | **0.4** | **0.4** |

| Эрэмбэ | Бүтээгдэхүүн | SBI |
|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн машин, эд ангиуд | 1.19 |
| 2 | Эмийн бүтээгдэхүүн | 1.09 |
| 3 | Альбуминойдын бодис, цавуу, энзим | 0.77 |
| 4 | Модны целлюлоз, цаас, цаасан карт | 0.48 |
| 5 | Эфирийн тос, үнэртэн, гоо сайхны бэлдмэл | 0.19 |
| 6 | Мах | 0.15 |
| 7 | Хивс, бусад шалны нэхмэл дэвсгэр | 0.00 |
| 8 | Ноос, амьтны үс | -0.04 |
| 9 | Сүүн бүтээгдэхүүн, өндөг, зөгийн бал | -0.06 |
| 10 | Үр тариа | -0.11 |
| 11 | Түлш, газрын тос | -0.22 |
| 12 | Амьд амьтан | -0.25 |
| 13 | Согтууруулах төрлийн ундаа | -0.27 |
| 14 | Газрын тосны үр, тослог жимс, эмчилгээний ургамал | -0.69 |
| 15 | Савхи, арьсан бүтээгдэхүүн | -0.70 |
| 16 | Хүдэр, шаар, үнс хөө | -0.72 |
| 17 | Элсэн чихэр, чихэр | -0.81 |

## Богино хугацаа

| | Жин | Зай | Complexity | Opp.gain |
|---|---|---|---|---|
| PTI | | **0.6** | 0.2 | 0.2 |

| Эрэмбэ | Бүтээгдэхүүн | PTI |
|---|---|---|
| 1 | Хүдэр, шаар, үнс хөө | 0.68 |
| 2 | Савхи, арьсан бүтээгдэхүүн | 0.29 |
| 3 | Ноос, амьтны үс | 0.23 |
| 4 | Түлш, газрын тос | 0.15 |
| 5 | Мах | 0.14 |
| 6 | Амьд амьтан | 0.08 |
| 7 | Газрын тосны үр, тослог жимс, эмчилгээний ургамал | 0.06 |
| 8 | Үр тариа | -0.04 |
| 9 | Элсэн чихэр, чихэр | -0.05 |
| 10 | Сүүн бүтээгдэхүүн, өндөг, зөгийн бал | -0.07 |
| 11 | Хивс, бусад шалны нэхмэл дэвсгэр | -0.09 |
| 12 | Альбуминойдын бодис, цавуу, энзим | -0.14 |
| 13 | Эмийн бүтээгдэхүүн | -0.18 |
| 14 | Эфирийн тос, үнэртэн, гоо сайхны бэлдмэл | -0.19 |
| 15 | Модны целлюлоз, цаас, цаасан карт | -0.19 |
| 16 | Согтууруулах төрлийн ундаа | -0.32 |
| 17 | Үйлдвэрийн машин, эд ангиуд | -0.37 |

- Манай оронд экспортыг хөгжүүлэх суурь орчин, оновчтой дэд бүтцийн шийдэл байхгүй байна. Тухайлбал, манай орон газарзүйн байршлын хувьд хоёр том гүрэнтэй хиллэдэг тул тухайн хоёр орны гадаад бодлогоос шууд хамааралтай. Экспортыг дэмжих бодлого байгаа ч тогтворгүй байдаг, мөн хэрэгжүүлэх стратеги, арга хэрэгсэл нь тодорхойгүй байдаг учраас хэрэгжилтийн түвшин хангалтгүй байсан ажээ. Улсын төсвөөс санхүүждэг, байнгын үйл ажиллагаатай, санхүүгийн чадавх болон ажилтнуудын тоо хүрэлцээтэй экспортыг дэмжих байгууллага байхгүй байна. Монгол улсын нэрлэсэн зээлийн хүү нь хөгжингүй орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь гадаад худалдаанд жижиг дунд эрхлэгчдийг өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд саад учруулж байна. Манай оронд гадаад худалдааны, тэр дундаа экспортын санхүүжилтийн үйлчилгээ хомс байдаг.

- Экспортын орлогыг бүрдүүлж буй бүтээгдэхүүний бүтцийг авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн хэт давамгайлсан, нэг салбараас хэт хамааралтай бүтэцтэй байна. Экспортын бүтээгдэхүүний төрлийн зохистой харьцаа алдагдсан тул уул уурхайн бус салбарын бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх замаар экспортын төрлийг солонгоруулан, орлогын эрсдэлийг бууруулах шаардлагатай байна.

- Эдийн засгийн цогц байдлын индекс (ECI) нь эдийн засгийг зөвхөн тодорхойлогч хүчин зүйл бус, түүний хөдөлгөгч хүч нь болдог байна. Иймд уул уурхайн салбарын түүхий эдийг гүнзгий боловсруулж, экспортод гаргах, уул уурхайн бус экспортын тэргүүлэх салбар, бүтээгдэхүүнийг ECI-д үндэслэн тогтоох шаардлагатай байна.

- Эдийн засгийн цогц байдлын индекс (ECI), бүтээгдэхүүний орон зайн шинжилгээг ашиглан манай орны экспортыг хамгийн үр ашигтайгаар төрөлжүүлэх боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойллоо. Монгол улс нь богино хугацаанд хүдэр, үнс хөө; савхи, арьсан бүтээгдэхүүн; ноос, амьтны үс; түлш, газрын тос; мах зэрэг бүтээгдэхүүний экспортыг дэмжсэнээр төрөлжилтийг хамгийн үр ашигтайгаар бий болгох боломжтой байна. Харин дунд болон урт хугацаанд хүнд үйлдвэрийн машин болон химийн гаралтай бүтээгдэхүүнүүд болох үйлдвэрийн машин, түүний эд ангиуд; эмийн бүтээгдэхүүн; альбуминойдын бодис, цавуу, энзим; модны целлюлоз, цаас, цаасан карт; эфирийн тос, үнэртэн, гоо сайхны бэлдмэл зэрэгт илүү анхаарал хандуулах шаардлагатай байна.

- *Д.Ган-Очир, “Түүхий эдийн үнийн уналт: Шилжих механизм, бодлогын асуудлууд,” 2017.*
- *Д.Ган-Очир, “Байгалийн баялгийг эдийн засгийн хөгжилд ашиглах нь: яагаад хүндрэлтэй байдаг вэ?” 2017.*
- *C. Hidalgo, B. Klinger, A. Barabasi ба R. Hausmann, “The Product Space Conditions the Development of Nations,” Science Magazine , б. 317, p. 5837, 2007.*
- *C. Hidalgo ба R. Hausmann, “The Building Blocks of Economic Complexity,” Proceedings of the National Academy of Sciences , б. 106, pp. 10570-10575, 2009.*
- *R. Hausmann, B. Cunningham, J. Matovu, R. Osire ба K. Wyett, “How should Uganda grow?,” CID Working Paper , б. 275, 2014.*
- *B. Song, “The rise of the Korean Economy,” Oxford University Press , 1990.*
- *Ц.Бямбацогт, “Гадаад худалдааг дэмжих механизмыг бий болгох нь”, 2012.*
- *D. Lederman, M. Olarreaga ба L. Payton, “Export Promotion Agencies: What Works and What Doesn't,” CEPR Discussion Paper , б. DP5810, 2008.*
- *Монголбанк, “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал,” 2017.*
- *M. Belloc ба M. D. Maio, “Survey of the Literature on Successful Strategies and Practices for Export Promotion by Developing Countries,” IGC working paper , 2011.*
- *R. Hausmann ба C. Hidalgo, “The Atlas of Economic Complexity,” Center for International Development at Harvard University , 2011.*
- *R. Hausmann, J. Hwanng ба D. Rodrik, “What you export matters,” Journal of Economic Growth , б. 12(1), 2007.*